



МОНГОЛ ТУТМЫН ХЭВЛЭЛ
УЛСЫН 12 ДУГААР САРЫН 06
№45 /666/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

1770

**Ан агнуурын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай**

Монгол Улсын
хууль

1784

**Захиргааны хэрэг хянан
шийдвэрлэх тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын
дэсгийн газрын
тогтоол

797

Хөтөлбөр батлах тухай

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|---|------|
| 400. | Ан агнуурын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1770 |
| 401. | Амьтны аймгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1782 |
| 402. | Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1783 |
| 403. | Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1784 |
| 404. | Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1795 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|------|
| 405. | Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг шингэцлэн тогтоох тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Дугаар 65 | 1796 |
|------|--|-----------|------|

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|--|------------|------|
| 406. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилдох тухай | Дугаар 240 | 1797 |
|------|--|------------|------|

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|-----------------------|------------|------|
| 407. | Хөтөлбөр батлах тухай | Дугаар 250 | 1797 |
|------|-----------------------|------------|------|

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- | | | | |
|------|--|-----------|------|
| 408. | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 07 | 1809 |
|------|--|-----------|------|



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 10 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

АН АГНУУРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ан агнуурын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг:

"2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө."

2/2¹ дүгээр зүйл:

"2¹ дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

2¹.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2¹.1.1. "агнуурын бүс нутаг" гэж агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах зориулалт бүхий ан амьтны байршил, тархац нутгийг;

2¹.1.2. "агнуурын амьтны сүргийн бүтэц" гэж сүрэг дэх ан амьтдын нас, хүйсийн харьцааг;

2¹.1.3. "ан агнуурын менежментийн төлөвлөгөө" гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн агнуур зохион байгуулалтын ажлын тайлан, дүгнэлтийг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ан агнах, барих зөвшөөрөл олгоход үндэслэл болох баримт бичгийг;

2¹.1.4. "агнуурын нөөцийг хамгаалах" гэж ан амьтны сүргийн бүтцийн төлөө байдлыг доройтохоос урьдчилан сэргийлэх, тэдгээрийн жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг алдагдуулахгүйгээр агнуурын нөөцийг зүй зохистой ашиглах, байгалийн гамшиг, түймэр, халдварт өвчин, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, агнуурын амьтны идэш тэжээлийн төлөө тэмцэл, хорогдлын шалтгааныг



олж тодорхойлох, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, сэргээн нутагшуулах, өсгөн үржүүлэх, тэдгээрт хяналт тавих цогц үйл ажиллагааг;

2¹.1.5.“агнуурын амьтныг өсгөн үржүүлэх” гэж ан амьтныг зохих журмын дагуу эзэмшилдээ авч, батлагдсан технологи, норм, нормативын дагуу тэжээврээр үржүүлэх замаар үр төлийг бойжуулан өсгөхийг;

2¹.1.6.“ангийн буу” гэж хийц, үзэмж, загвараараа байлдааны зэвсгээс ялгаатай, замагтай бууны хүхээнд 5-аас дээшгүй, өөрөө цэнэглэгдэгч (хагас автомат) бууны хүхээнд 4-өөс дээшгүй сумны багтаамжтай галт зэвсгийг;

2¹.1.7.“спорт (трофейн) агнуур” гэж анчин ан агнах, барих хэрэгцээгээ хангах зорилгоор ан амьтны эд, эрхтнийг үзүүлэлтийн хувьд сонголт болгоггүй агнах, барих үйлийг;

2¹.1.8.“олзворын ан” гэж ан амьтны илүү үзүүлэлт бүхий эд, эрхтнийг азах зорилгоор тусгай төлбөр төлж агнах, барих үйлийг;

2¹.1.9.“агнах, барихыг түр хориглосон ан амьтан” гэж хуулиар агнах, барихыг хориглоогүй ч гэсэн тархац, нөөц, хэвийн өсөлт үржилт, амьдрах орчин нөхцөл нь хомсдсон, муудсан, доройтсоны улмаас энэ хуулийн 3¹.2, 3¹.3-д заасан эрх бүхий байгууллагаас агнах, барихыг нь тодорхой хугацаагаар хориглосон амьтныг.”

3/3 дугаар зүйлийн 3.5-3.7 дахь хэсэг:

“3.5.Энэ хуулийн 3.4-т заасан гэрээг зохих бэлтгэл хангуулах зорилгоор эхний ээлжинд 1 жилийн хугацаагаар, цаашид арван жилийн давтамжтайгаар 30 хүртэл жилийн хугацаагаар байгуулж болно. -

3.6.Энэ хуулийн 3.4-т заасан агнуурын бүс нутгийн тодорхой хэсгийг эзэмшигч нь ан агнуурын менежментийн төлөөлөгөөний дагуу эзэмшлийнхээ агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээ авна.

3.7.Иргэн өөрийн өмчийн болон эзэмшлийн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газартаа энэ хуулийн 3¹.3.5-д заасан технологи, норм, нормативын дагуу агнуурын амьтныг тэжээврээр үржүүлж болно.”

**4/3^а дүгээр зүйл:**

3^а дүгээр зүйл. Ан агнуурын талаар төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

3^а.1. Ан агнуурын талаар Улсын Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3^а.1.1. ан агнуурын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

3^а.1.2. агнуурын нөөц ашигласны төлбөрийн дээд, доод хувь, хэмжээг тогтоох;

3^а.1.3. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

3^а.2. Ан агнуурын талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3^а.2.1. агнуурын нөөцийг ашиглах, импортлох, экспортлох хэмжээг хуульд заасан үндэслэлээр хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох;

3^а.2.2. ан агнуурын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

3^а.2.3. агнуурын нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсөвт тусгах;

3^а.2.4. энэ хуулийн 4.3-т заасан байгууллагын ажиллах журмыг батлах;

3^а.2.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

3^а.3. Ан агнуурын талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3^а.3.1. ан агнуурын ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлага зохицуулалт, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;

3^а.3.2. агнуурын нөөц бүхий аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг батлах, уг менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

3^а.3.3. агнуурын амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг боловсруулж, батлуулах;



З¹.3.4.экологийн шаардлага, нөөцийг харгалзан тухайн агнуурын бүс нутагт ан хийх, эсхүл зарим зүйл агнуурын амьтныг агнах, барихыг тодорхой хугацаагаар хориглох;

З¹.3.5.агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх талаар технологи, норм, нормативыг батлах;

З¹.3.6.агнуурын нөөцийн өөрчлөлтөд хяналт шинжилгээ хийх, ан агнуурын мэдээллийн сан бүрдүүлж, мэдээллээр хангах;

З¹.3.7.ан агнуурын чиглэлээр нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ан агнуурын менежментийн төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, тэдгээрийг боловсруулах заавар, журам батлах;

З¹.3.8.агнуурын нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийг хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах;

З¹.3.9.судалгаа, шинжилгээ, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор энэ хуулийн 13.1-13.6-д заасан хугацааг харгалзахгүйгээр ан амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох.

З¹.4.Ан агнуурын талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

З¹.4.1.энэ хуулийн 3.3-т заасан агнуурын бүс нутгийг тогтоох;

З¹.4.2.ан агнуурын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

З¹.4.3.агнуурын нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсөвт тусгах;

З¹.4.4.агнуурын амьтныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, бусад шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

З¹.4.5.агнуурын нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилгоор тодорхой агнуурын бүс нутгийг орон нутгийн хамгаалалтад авах;

З¹.4.6.агнуурын нөөцийн талаархи мэдээ, тайланг энэ хуулийн З¹.3-т заасан эрх бүхий байгууллагад хүргүүлэх;



3¹.4.7.харьяалах нутаг дэвсгэртээ байршдаг агнуурын амьтныг хамгаалах арга хэмжээг байгаль орчны хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх;

3¹.4.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

3¹.5.Ан агнуурын талаар аймаг, нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын газар, хэлтэс дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3¹.5.1.агнуурын нөөцөд тулгуурлан жил бүр ашиглах агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоох санал боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэх;

3¹.5.2.агнуурын нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх талаар эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

3¹.5.3.энэ хуулийн 3¹.3.2-т заасан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

3¹.5.4.орон нутаг дахь агнуурын амьтныг хамгаалах чиглэлийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангах;

3¹.5.5.харьяалах нутаг дэвсгэртээ ан агнуурын мэдээллийн сан бүрдүүлж, мэдээллээр хангах."

5/8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг:

"8.3.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 8.2-т заасан агнуурын амьтны тоо хэмжээнд багтаан өөрийн нутаг дэвсгэрт агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийг иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад олгож болно."

6/12¹ дүгээр зүйл:

"12¹ дүгээр зүйл. Иргэн, нөхөрлөл, ан агнуурын мэргэжлийн болон төрийн бус байгууллагыг агнуурын нөөцийг хамгаалахад оролцуулах

12¹.1.Ан агнах зөвшөөрөл бүхий иргэн агналт хийхдээ дараахь шаардлагыг хангасан байна:



12¹.1.1.ан амьтан агнах, барих төлбөр, зөвшөөрлийн хураамж төлсөн байх;

12¹.1.2.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан агнуурын амьтан агнах, барих хугацааг чанд мөрдөх;

12¹.1.3.ан амьтан агнах, барихдаа энэ хуулийн 14 дүгээр зүйлээр хориглосон арга, зэвсэг хэрэгсэл хэрэглэхгүй байх;

12¹.1.4.агнах амьтан нь тухайн сум, дүүргийн агнуурын бүс нутгаас тухайн жилд агнахаар зөвшөөрөгдсөн амьтдын тоо хязгаарт багтаж байх;

12¹.1.5.агналт хийх агнуурын бүс нутгаа сум, дүүргийн байгаль хамгаалагчаар заалгасан байх;

12¹.1.6.агнуурын ховор загасыг зөвхөн нэг салаа сэтгүүртэй, үзүүртээ сэртэнгүй дэгээг ашиглаж, хиймэл өгөөшөөр гэмтээлгүй барьж, усанд нь буцааж тавих.

12¹.2.Агнуурын нөөцийг хамгаалах талаар нөхөрлөл дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

12¹.2.1.гэрээний үндсэн дээр хамгаалахаар хариуцаж байгаа агнуурын бүс нутгийнхаа агнуурын нөөцийг хуулийн хүрээнд гэрээнд заасны дагуу тогтвортой ашиглах, эзэмших давуу эрхтэй;

12¹.2.2.агнуурын нөөцийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших талаар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31¹.3-т заасан журмыг мөрдөж ажиллах.

12¹.3.Агнуурын нөөцийг хамгаалах зорилго бүхий мэргэжлийн байгууллага дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

12¹.3.1.агнуурын нөөц, түүний тооллого бүртгэл, агнуур зохион байгуулалтын ажлыг улс, орон нутгийн болон нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын захиралга, хөрөнгөөр гүйцэтгэх, тэдгээрийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулах;

12¹.3.2.агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх чиглэлээр мэргэжлийн дүгнэлт гаргах;

12¹.3.3.агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх талаар нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил,



арга зүйн зөвлөлгөө өгөх, сургалт явуулах, төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх;

12¹.3.4.өөрийн гүйцэтгэсэн ажлын үнэн зөвийг хариуцаж, үйл ажиллагааныхаа талаар төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;

12¹.3.5.Амьтны аймгийн тухай хуулийн 22.4-т заасны дагуу агнуурын байршил нутагт халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх.

12¹.4.Агнуурын нөөцийг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллага дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

12¹.4.1.ан агнуурын тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

12¹.4.2.ан агнуурын талаархи саналаа холбогдох төрийн байгууллага болон зохих шатны иргэдийн Хурал, Засаг даргад уламжлах;

12¹.4.3.агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх;

12¹.4.4.ан агнуурын тухай мэдлэг, ангийн нөөцийг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомжийг сурталчлах.

12¹.5.Төрийн захиргааны төв байгууллага агнуурын нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх талаархи төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32.2-т заасны дагуу агнуурын нөөцийг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно.”

7/14 дүгээр зүйлийн 14.1.9 дэх заалт:

“14.1.9.гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах.”

8/15 дугаар зүйлийн 15.1.13 дахь заалт:

“15.1.13.агнахыг хориглосон ан амьтны арьс шир, үс, өд, эвэр, толгой, цус, өөх, тос зэрэг эд эрхтнийг худалдах, худалдан авах.”

9/16 дугаар зүйлийн 16.1.8 дахь заалт:

"16.1.8.хууль тогтоомжийн холбогдох заалтыг зөрчиж ан амьтныг агнах, барих зөвшөөрөл олгосон, эсхүл ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаадад гаргах гэрчилгээ олгосон албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох."

10/18 дугаар зүйл:

"18 дугаар зүйл.Агнуурын нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх

18.1.Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас агнуурын нөөцөд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

18.2.Энэ хуулийн 7.3-т заасан тодорхойлолт аваагүй ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг цуглуулсан, худалдсан, худалдан авсан, гадаадад гаргахыг завдсан этгээдийг тухайн зүйл ан амьтныг агнасан, барьсантай адилтган үзэж, нөхөн төлбөр ногдуулна.

18.3.Эрхийн бичиг, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн, түүнчлэн зөвшөөрөлгүй агнасан этгээдэд нөхөн төлбөр ногдуулна.

18.4.Нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газраас тогтоосон амьтны экологи-эдийн засгийн үнэлгээгээр тогтооно."

2 дугаар зүйл.Ан агнуурын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1 дэх заалтын "улсын төсөв" гэсний өмнө "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуулийн 4.1-д заасны дагуу" гэж, мөн зүйлийн 4.5.2 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.1.1-16.1.6 дахь заалтын "аж ахуйн нэгж" гэсний өмнө "нөхөрлөл," гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн "дээд хязгаарыг" гэсний дараа ", энэ хуулийн 3¹.3.3, 3¹.5.1-д заасан" гэж, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн "бусад" гэсний дараа "агнуурын" гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн "Агнуурын амьтныг" гэсний дараа "тусгай зориулалтаар" гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн "хуваарилалтыг" гэсний дараа "цагдаагийн төв байгууллага" гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтын "урхи тавих," гэсний өмнө "хавх," гэж, мөн зүйлийн 14.1.5 дахь заалтын "автотээврийн хэрэгслээр хөөх" гэсний дараа ", гэрэлтүүлэх" гэж, 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтын "15.1.7," гэсний дараа "15.1.8," гэж, мөн зүйлийн 16.1.5 дахь заалтын "14.1.8," гэсний дараа "14.1.9," гэж, "15.1.10" гэсний дараа ", 15.1.13" гэж тус тус нэмсүгэй."



3 дугаар зүйл. Ан агнуурын тухай хуулийн дараахь зүйл, хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.3-3.4 дэх хэсэг:

"3.3.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь агнуурын амьтны тархац нутагт ан амьтныг агнах, барих агнуурын бүс нутгийг энэ хуулийн 3¹.3.2-т заасан ан агнуурын менежментийн төлөвлөгөөг үндэслэн тогтооно.

3.4.Агнуурын амьтны нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, ангийн гаралтай түүхий эд бэлтгэх зорилгоор агнуурын бүс нутгийн тодорхой хэсгийг гэрээний дагуу иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж болно."

2/4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг:

"4.2.Агнуур зохион байгуулалтын тайлан, дүгнэлт болон энэ хуулийн 3¹.3.2-т заасан ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд агнуурын бүс нутгийн хэмжээ, хил хязгаарыг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд тогтоож өгсөн байна."

3/11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг:

"11.1.Тусгай төлбөр төлсөн Монгол Улсын болон гадаадын иргэнд энэ хуулийн 6.2.3-т заасан зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно."

4/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

"12.2.Аугийн буу, сумыг захиалах, худалдах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага хянаж, зохион байгуулна."

5/13 дугаар зүйл:

"13 дугаар зүйл.Агнуурын амьтан агнах, барихыг хориглох хугацаа

13.1.Агнуурын амьтныг дор дурдсан хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглоно:

13.1.1.Бор гөрөөс, цагаан эээр, гахайг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

13.1.2.ойн булга, хадны суусар, элбэнх, шилүүс, нохой зээх, үнэг, хярс, хэрэм, ойн солонго, усны булга, өмхий хүрнэ, мануул, хотны үен, цагаан үен, чандага, бор туулайг жил бүрийн 02 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл;

13.1.3.зурам, тарвагыг жил бүрийн 10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

13.1.4.заарт хархыг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл;

13.1.5.доргыг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөс дараа оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хүртэл.

13.2.Ахуйн болон тусгай зориулалтаар дор дурдсан хугацаанд шувуу агнах, загас барихыг хориглоно;

13.2.1.хөгүү, ятуу, хахилга, ногтруу, хур сойрыг жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

13.2.2.галуу, нугас болон ус, намгийн бусад агнуурын шувууг жил бүрийн 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдөр, 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

13.2.3.дархадын цагаан загасыг жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

13.2.4.Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэл;

13.2.5.омоль загасыг жил бүрийн 8 дугаар сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл;

13.2.6.зарам загасыг жил бүрийн 9 дүгээр сарын 05-ны өдрөөс дараа оны 01 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл;

13.2.7.алтайн сугас загасыг жил бүрийн 6 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

13.2.8.энэ хуулийн 13.2.3-13.2.7-д зааснаас бусад загасыг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл.



13.3.Тусгай зориулалтаар агнуурын ховор амьтныг агнах, барихыг хориглох хугацааг энэ хуулийн 13.6-13.7-д заасны дагуу тогтооно.

13.4.Судалгаа, шинжилгээ, халдварт өвчнийг эрүүлжүүлэх зорилгоор агнуурын амьтныг агнах, барих тохиолдолд энэ хуулийн 13.1-13.3-т заасан хугацааг харгалзахгүй байж болно.

13.5.Энэ хуулийн 13.1-13.4-т зааснаас бусад агнуурын амьтан агнах, барихыг хориглох хугацааг эрдэм шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

13.6.Амьтны аймгийн тухай хуулийн 7.5-д заасан үндэслэлээр агнах ховор амьтныг дор дурдсан хугацаанд олзворын ангийн зориулалтаар агнахыг хориглоно:

13.6.1.угалзыг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл;

13.6.2.тэхийг жил бүрийн 10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 7 дугаар сарын 14-ний өдөр хүртэл;

13.6.3.хар сүүлтийн зээрийн ооныг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

13.6.4.халиун бугыг жил бүрийн 9 дүгээр сарын 30-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл.

13.7.Амьтны аймгийн тухай хуулийн 7.5-д заасан үндэслэлээр барих ховор амьтныг дор дурдсан хугацаанд судалгаа, шинжилгээнээс бусад тусгай зориулалтаар амьдаар барихыг хориглоно:

13.7.1.аргаль хонь, янгир ямааг жил бүрийн 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

13.7.2.хар сүүлтийн зээрийг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрөөс дараа оны 7 дугаар сарын 15-ны өдөр хүртэл;

13.7.3.халиун бугыг жил бүрийн 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

13.7.4.идлэг шонхор шувууг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

13.7.5.цармын бүргэдийг жил бүрийн 11 дүгээр сарын 01-

ний өдрөөс дараа оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл;

13.7.6.тул загасыг жил бүрийн 10 дугаар сарын 30-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл."

6/16 дугаар зүйлийн 16.1.7 дахь заалт:

"16.1.7.зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох."

4 дүгээр зүйл. Ан агнуурын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн "зохистой" гэснийг "тогтвортой" гэж, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн "газар нутгийн агнуурын амьтны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, өсгөн үржүүлэх үндэслэл" гэснийг "агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг" гэж, мөн зүйлийн 4.4 дэх хэсгийн "4 жил" гэснийг "5 жил" гэж, мөн зүйлийн 4.5.2 дахь заалтын "байршил" гэснийг "агнуурын бүс" гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн "Холбогдох" гэснийг "Ан агнах ёс жаяг, хорио цээр, холбогдох" гэж, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн "байгаль орчны улсын байцаагч" гэснийг "байгаль хамгаалагч" гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн "6.1-д" гэснийг "12'.1-д" гэж, 11 дүгээр зүйлийн 11.2.2 дахь заалтын "тусгай төлбөр төлж" гэснийг "спорт агнуур болон олзворын ангийн чиглэлээр" гэж, 15 дугаар зүйлийн 15.1.11 дэх заалтын "30x30" гэснийг "50x50" гэж, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтын "5000-10000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 0.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж, "50000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж, мөн зүйлийн 16.1.2 дахь заалтын "15.10-г" гэснийг "12'.1.6, 15.1.2-г" гэж, "1000-5000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний" гэж, "50000-75000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж, мөн зүйлийн 16.1.3 дахь заалтын "2000-5000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний" гэж, "10000-60000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж, "50000-100000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж, мөн зүйлийн 16.1.4 дэх заалтын "10000-15000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний" гэж, "75000-100000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж, мөн зүйлийн 16.1.5 дахь заалтын "10000-20000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж, "75000-150000"



гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж, мөн зүйлийн 16.1.6 дахь заалтын "10000-25000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж, "100000-200000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн дугаарыг "8.4" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Ан агнуурын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн "тул загас 2," гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалтын "ховор" гэснийг, 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь заалтын "агнуурын байршил" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Ан агнуурын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 10 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

АМЬТНЫ АЙМГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Амьтны аймгийн тухай хуулийн 7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 7.7 дахь хэсэг нэмсүгэй:

"7.7. Энэ хуулийн 7.5-д заасан үндэслэлээр ховор амьтныг агнах, барихтай холбогдсон харилцааг Ан агнуурын тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар нарийвчлан зохицуулна."

2 дугаар зүйл. Амьтны аймгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.2, 17.3 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 20.3.1, 20.3.2 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1.1-27.1.5 дахь заалтын "аж ахуйн нэгж" гэсний өмнө "нөхөрлөл," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Амьтны аймгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийн "жагсаалтыг" гэснийг "жагсаалт, ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох журмыг" гэж, 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтын "5000-10000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 0.5 дахин



нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “50000” гэснийг “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 27.1.2 дахь заалтын “20000-50000” гэснийг “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “50000-250000” гэснийг “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 27.1.3 дахь заалтын “35000-50000” гэснийг “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “150000-250000” гэснийг “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 27.1.4 дэх заалтын “35000-50000” гэснийг “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “75000-200000” гэснийг “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 27.1.5 дахь заалтын “10000-50000” гэснийг “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “50000-25000” гэснийг “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 10 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

АГНУУРЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР, АН АМЬТАН АГНАХ, БАРИХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 1 дүгээр зүйл, 3 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 1, 3, 5 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн “аж ахуйн нэгж” гэсний өмнө “нөхөрлөл,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “25000 хүртэл” гэснийг “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2010 оны 10 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт:

"8.1.4.захиргааны актыг хэвээр үлдээх."

2/12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:

"12.3.Нэхэмжлэгч энэ хуулийн 12.1, 12.2-т заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ тухайн захиргааны хэргийн шүүхэд гаргаж болох бөгөөд уг хүсэлтийг хангах эсэхийг шүүгч захирамж гарган шийдвэрлэнэ."

3/15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг:

"15.4.Захиргааны хэргийн шүүхийн харьяаллын талаар гарсан шүүх хоорондын маргааныг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын тэргүүн шийдвэрлэнэ."

4/19 дүгээр зүйлийн 19.2.4-19.2.6 дахь заалт:

"19.2.4.захиргааны хэргийн шүүхэд хэргийн талаар үнэн зөв тайлбар гаргах;

19.2.5.захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хуульд заасан хугацаанд гардан авах;

19.2.6.захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэх."

5/45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсэг:

"45.3.Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн шүүгчийн захирамж нь тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна."



6/49 дүгээр зүйлийн 49.3 дахь хэсэг:

"49.3.Хэргийн оролцогч шүүх хуралдааны товыг шүүхээс лавлах үүрэг хүлээнэ."

7/53¹ дүгээр зүйл:

"53¹ дүгээр зүйл.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд шүүгч оролцож болохгүй үндэслэл

53^{1.1}.Захиргааны хэргийг анхан болон давж заалдах, хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэхэд урьд нь оролцсон шүүгч уг хэрэг, маргааныг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.

53^{1.2}.Захиргааны хэргийг анхан болон давж заалдах, хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгчийн гэр бүлийн гишүүн, түүнтэй төрөл, садангийн холбоотой шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй."

8/74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсэг:

"74.3.Энэ хуулийн 34.1-д заасан үндэслэл хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үед тогтоогдвол шүүх тогтоол, шүүгч захирамж гарган хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана."

9/83 дугаар зүйлийн 83.3 дахь хэсэг:

"83.3 Энэ хуулийн 41, 42, 43 дугаар зүйлд заасан нөхцөл байдал шүүх хуралдаан эхлэхээс өмнө илэрвэл шүүгч захирамж, шүүх хуралдаанаар хэргийг хянан хэлэлцэх явцад илэрвэл шүүх тогтоол гарган, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснийг, нэхэмжлэгч, хариуцагч эвлэрснийг баталж хэргийг хэрэгсэхгүй болгоно."

10/86 дугаар зүйлийн 86.6 дахь хэсэг:

"86.6.Энэ хуулийн 86.5-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтийг анхан шатны шүүхэд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсэхийг шүүгч захирамж гарган шийдвэрлэнэ."

**11/88 дугаар зүйлийн 88.4 дэх хэсэг:**

"88.4.Давж заалдах журмаар хэрэг хянан хэлэлцэх явцад энэ хуулийн 34.1-д заасан үндэслэл илэрвэл энэ хуулийн 88.1,3-т заасан шийдвэрийг гаргана."

12/90 дүгээр зүйлийн 90.3 дахь хэсэг:

"90.3.Энэ хуулийн 90.2-т заасан тогтоол нь эцсийн шийдвэр байна."

2 дугаар зүйл.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн "Эрүүгийн хууль" гэсний дараа ", Захиргааны хариуцлагын тухай хууль" гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн "тохиолдолд" гэсний дараа "энэ хуулийн 6.1-д заасан хугацаанд" гэж, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн "нэхэмжлэлийг" гэсний дараа "шүүгчийн захирамж гаргаж" гэж, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтын "бүрэн эрхгүй" гэсний дараа "болон нэхэмжлэл гаргах эрхгүй" гэж, мөн зүйлийн 34.1.6 дахь заалтын "буюу" гэсний дараа "шүүхийн тогтоол," гэж, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн "хүлээн авсан" гэсний дараа ", эсхүл нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж ирүүлсэн" гэж, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсгийн "хуулийн" гэсний дараа "41," гэж, 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтын "оролцогчийн" гэсний дараа "гэр бүл," гэж, "хоорондоо" гэсний дараа "гэр бүлийн болон" гэж, мөн зүйлийн 64.1.3 дахь заалтын "чадах" гэсний дараа "эсэх" гэж, 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсгийн "гаргаж" гэсний дараа "нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснийг, нэхэмжлэгч, хариуцагч эвлэрснийг баталж" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1.10 дахь заалт:

"3.1.10."шүүхийн тогтоол" гэж захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх бүрэлдэхүүнээс гаргасан болон хяналтын шатны шүүх захиргааны хэргийг хянаад гаргасан шийдвэрийг;"

2/3 дугаар зүйлийн 3.1.13 дахь заалт:

"3.1.13."шийтгэвэр" гэж захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад захиргааны зөрчил гаргасан этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулсан шийдвэрийг."



3/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:

"5.1.Захиргааны хэргийн шүүхийн акт нь шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэр гэсэн хэлбэртэй байна."

4/15 дугаар зүйлийн 15.2.2 дахь заалт:

"15.2.2.давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийг хяналтын шатны."

5/20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2 дахь заалт:

"20.1.1.нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх, эсхүл татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэгчтэй эвлэрэх;

20.1.2.энэ хуулийн 19.1.2-19.1.7-д заасан эрх."

6/20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт:

"20.2.2. энэ хуулийн 19.2-т заасан үүрэг."

7/21 дүгээр зүйл:

"21 дүгээр зүйл. Гуравдагч этгээд

21.1.Тухайн захиргааны актын талаар бие даасан шаардлага гаргасан, эсхүл уг актын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа гэж үзсэн гуравдагч этгээдийг шүүгч захирамж гарган захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж болно.

21.2.Гуравдагч этгээд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ."

8/26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг:

"26.1.Иргэний эрх зүйн чадамж бүхий иргэн шаардлагатай гэж үзвэл захиргааны хэргийг хянан хэлэлцэхэд төлөөлөгчөө оролцуулна."

9/27 дугаар зүйлийн 27.2.2 дахь заалт:

"27.2.2.нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх;"

10/29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг:

"29.1.Хэргийн оролцогчийн хүсэлтийг үндэслэн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцож болно."

**11/32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг:**

"32.1.Нэхэмжлэлийг шүүхэд бичгээр гаргах бөгөөд нэхэмжлэлд нэхэмжлэгч, эсхүл түүнийг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлж байгаа этгээд гарын үсэг зурсан байна."

12/32 дугаар зүйлийн 32.3 - 32.5 дахь хэсэг:

"32.3.Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, түүнчлэн нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлийг хавсаргана.

32.4.Нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө.

32.5.Энэ хуулийн 32.2.3-т заасан нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл гэдэгт дараахь зүйл багтана:

32.5.1.захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус актын улмаас нэхэмжлэгчийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрхэн зөрчигдсөн;

32.5.2.захиргааны хэргийн шүүхээс ямар шийдвэр гаргуулж зөрчигдсөн эрхээ хэрхэн сэргээлгэхийг хүсэж байгаа, түүний үндэслэл;

32.5.3.захиргааны хууль бус актын улмаас ямар хохирол учирсан, түүнийг хэрхэн шийдвэрлүүлэх."

13/34 дүгээр зүйлийн 34.1.8 дахь заалт:

"34.1.8.энэ хуулийн 12.1, 12.2-т заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн бол."

14/34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэг:

"34.2.Нэхэмжлэлийг энэ хуулийн 34.1-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзахдаа шүүгч захирамж гарган татгалзсан шалтгааныг зааж, уг нэхэмжлэлийг хэрхэн мэдүүлэх, эсхүл шүүх түүнийг хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж өгч, нэхэмжлэлийг нэхэмжлэгчид буцаана."

15/43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсэг:

"43.4.Энэ хуулийн 41, 42, 43 дугаар зүйлийн дагуу хэргийг хянан



шийдвэрлэсэн тохиолдолд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч тухайн асуудлаар дахин анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах, хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхгүй.”

16/54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэг:

“54.2.Шүүх хуралдаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгч, хэргийн оролцогчийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг бусад оролцогч гэнэ.”

17/62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг:

“62.1.Шүүх хуралдааныг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс томилсон шүүгч даргална.”

18/64 дүгээр зүйлийн 64.1.1 дэх заалт:

“64.1.1.урьд нь уг захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, прокурор, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчээр оролцож байсан;”

19/66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсэг:

“66.3.Энэ хуулийн 66.2-т заасны дагуу хэрэг шилжэж ирсэн тохиолдолд зохих хуваарийн дагуу тухайн захиргааны хэргийн шүүхийн шүүгч хүлээн авч хянан шийдвэрлэнэ.”

20/73 дугаар зүйл:

**73 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийг танилцуулах,
шийдвэр хүчинтэй болох**

73.1.Шүүх хуралдаан даргалагч шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг танилцуулж, шаардлагатай бусад асуудлыг тайлбарлан шүүх хуралдааныг хаана.

73.2.Шүүхийн шийдвэр танилцуулан сонгосноор хүчинтэй болно.

73.3.Шүүхийн шийдвэр хүчинтэй болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор шийдвэрийн агуулгыг энэ хуулийн 72 дугаар зүйлд заасны дагуу



бүрэн эхээр нь бичгээр үйлдэж шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна.

73.4.Шүүх хуралдаанд оролцсон хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 73.3-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор шүүхэд хүрэлцэн ирж шүүхийн шийдвэрийг өөрөө гардан авна.

73.5.Хэргийг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн оролцоогүйгээр шийдвэрлэсэн бол шүүх шийдвэрийг энэ хуулийн 73.4-т заасан хугацаанд гардуулна. Ийнхүү гардуулах боломжгүй, эсхүл энэ хуулийн 73.4-т заасны дагуу хүрэлцэн ирж шүүхийн шийдвэрийг гардан аваагүй бол шүүх шүүхийн шийдвэрийг уг хугацаа өнгөрснөөс хойш 7 хоногийн дотор хэргийн оролцогчийн оршин суугаа /оршин байгаа/ газар болон ажилладаг байгууллагын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар хүргүүлнэ.

73.6.Энэ хуулийн 73.5-д заасны дагуу хүргүүлснийг гардан авсанд тооцох бөгөөд шүүхийн шийдвэрийг хүргүүлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77.6-д заасан журмыг баримталж болно.”

21/77 дугаар зүйл:

“77 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох

77.1.Анхан шатны шүүхийн шийдвэр дараахь тохиолдолд хуулийн хүчин төгөлдөр болно:

77.1.1.энэ хуулийн 81.1-д заасан хугацаанд давж заалдах гомдол гаргаагүй;

77.1.2. давж заалдах гомдол гаргасан бөгөөд давж заалдах шатны шүүх гомдлыг хянан хэлэлцээд энэ хуулийн 87.1, 87.3-т заасны дагуу гаргасан магадлалд хяналтын журмаар гомдол гаргаагүй;

77.1.3.давж заалдах шатны шүүхийн магадлалд хяналтын журмаар гомдол гаргасан бөгөөд хяналтын шатны шүүх гомдлыг хянан хэлэлцээд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176.2.1-176.2.3-т заасан тогтоол гаргасан.

77.2.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, түүнчлэн хэргийн оролцогчийн эрх залгамжлагч шүүхээр нэгэнт хянан



шийдвэрлэсэн маргааны талаар дахин шүүхэд нэхэмжлэл гаргах буюу шүүхээс нэгэнт тогтоосон үйл баримт, эрх зүйн харилцаа, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх өөр ажиллагааны талаар маргах эрхгүй.”

22/79 дүгээр зүйл:

“79 дүгээр зүйл. Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, тэдгээрийг хүчингүй болгох, өөрчлөх

79.1.Энэ хуулийн 70 дугаар зүйлд зааснаар шийдвэр гаргаснаас бусад захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шийдвэрлэж байгаа асуудлаар шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

79.2.Хуульд гомдол гаргахаар заасан болон шүүх хуралдааны бус үед хянан шийдвэрлэж байгаа асуудлаар шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг бичгээр гаргана.

79.3.Энэ хуулийн 79.1-д заасны дагуу гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж илт үндэслэл муутай бол тухайн шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гарган хүчингүй болгох, эсхүл өөрчилж болно.”

23/81 дүгээр зүйл:

“81 дүгээр зүйл. Давж заалдах гомдол гаргах, гомдлыг хүлээн авах

81.1.Анхан шатны журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлээд гаргасан захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч 14 хоногийн дотор Улсын дээд шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй.

81.2.Давж заалдах гомдлыг шийдвэр гаргасан захиргааны хэргийн шүүхээр дамжуулан гаргана.

81.3.Давж заалдах журмаар гомдол гаргаагүй этгээд хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй.

81.4.Давж заалдах гомдлын үндэслэлд анхан шатны шүүхээр хэлэлцээгүй шинэ нотлох баримтыг заах эрхгүй.

81.5.Давж заалдах гомдлыг тухайн захиргааны хэргийг шийдвэрлэсэн шүүхийн нарийн бичгийн дарга хүлээн авч, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчид танилцуулах бөгөөд тэдгээрийн тайлбарыг авч хэрэгт хавсаргаж болно.



81.6.Энэ хуулийн 81.2-т заасан шүүх нь давж заалдах гомдолд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчөөс гаргасан тайлбарыг хавсарган хэргийн хамт уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нийслэлд 3, орон нутагт 7 хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

81.7.Давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргасан бол гомдлыг хянан шийдвэрлэх хүртэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахгүй.

81.8.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 81.1-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ анхан шатны шүүхэд гаргах бөгөөд уг хүсэлтийг хангах эсэхийг шүүгч захирамж гарган шийдвэрлэнэ."

24/83 дугаар зүйлийн 83.2 дахь хэсэг:

"83.2.Давж заалдах гомдол гаргасан этгээд шүүх хуралдаан эхлэхээс өмнө гомдлоосоо татгалзвал түүнийг гомдол гаргаагүйд тооцож шүүгч захирамж, харин шүүх хуралдааны явцад татгалзвал давж заалдах журмаар хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг хэрэгсэхгүй болгож, шүүх тогтоол гаргана. Энэ тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгоно."

25/84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэг:

"84.1.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох хүсэлтээ бичгээр гаргах ба энэ тохиолдолд шүүх давж заалдах шатны шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг мэдэгдэж, тэдгээрийн шүүх хуралдаанд оролцох эрхийг хангах үүрэгтэй."

26/ 86 дугаар зүйлийн 86.3-86.5 дахь хэсэг:

"86.3.Магадлал танилцуулан сонгосноор хүчинтэй болно.

86.4.Магадлал хүчинтэй болсноос хойш 7 хоногийн дотор магадлалын агуулгыг бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна. Магадлалыг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 73.4-т заасны дагуу гардан авах, эсхүл шүүх энэ хуулийн 73.5-д заасны дагуу хүргүүлнэ.

86.5.Давж заалдах шатны шүүхийн магадлалд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172.2-т заасан үндэслэлээр хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн



86.4-т заасны дагуу гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор хяналтын журмаар гомдол гаргаж болно.”

27/88 дугаар зүйлийн 88.1.3 дахь заалт:

“88.1.3.анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгон нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах;”

28/ 90 дүгээр зүйлийн 90.1 дэх хэсэг:

“90.1.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 12.3, 31.7, 31.8, 34.2, 45.1, 48.1, 65.2, 69.2, 74.2, 74.3, 79.3-т заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор Улсын дээд шүүхэд гомдол гаргаж болно.”

29/ 90 дүгээр зүйлийн 90.2, 2, 90.2.3 дахь заалт:

“90.2.2.захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг өөрчлөх;

90.2.3.захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хүчингүй болгох.”

4 дүгээр зүйл.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9, 3.1.11, 3.1.12 дахь заалтын “баримт бичгийг” гэснийг “шийдвэрийг” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “нэхэмжлэгчийн” гэснийг “гомдол гаргагчийн” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3 дахь заалтын “заасан журмын” гэснийг “заасны” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “шийдвэр” гэснийг “захиргааны акт” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2.3 дахь заалтын “шаардлага, шийдвэрийг” гэснийг “шаардлагыг” гэж, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “үзүүлнэ” гэснийг “гаргаж өгнө” гэж, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийн “хэлэлцэхэд гэрээгээр” гэснийг “шийдвэрлэх ажиллагаанд” гэж, 31 дүгээр зүйлийн 31.8 дахь хэсгийн “хасах” гэснийг “хасч, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргах” гэж, 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын “шаардлагын агуулга,” гэснийг “шаардлагын үндэслэл,” гэж, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн “77.2-77.9-д” гэснийг “77 дугаар зүйлд” гэж, 44 дүгээр зүйлийн гарчгийн “Нэхэмжлэлийн шаардлагыг” гэснийг “Хэргийг” гэж, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш аймгийн төвд 40, нийслэлд 30” гэснийг “хэрэг үүсгэснээс хойш 60” гэж, 52 дугаар зүйлийн 52.1.1 дэх заалтын “4.1.1-4.1.3-т” гэснийг “4.1.2, 4.1.3-т” гэж, 56 дугаар зүйлийн 56.2.3 дахь заалтын “нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн



төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд” гэснийг “хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч” гэж, 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсгийн “зохигч” гэснийг “хэргийн оролцогч” гэж, 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсгийн “захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар дээд шатны шүүхэд” гэснийг “тухайн захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч захирамж гарган” гэж, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийн “100.2-100.4, 101-113 дугаар зүйлд” гэснийг “100.3, 100.4, 101-114 дүгээр зүйлд” гэж, 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсгийн “шийдвэрийн аль нэгийг” гэснийг “шийдвэрийг” гэж, мөн зүйлийн 70.2.6 дахь заалтын “иргэнд” гэснийг “иргэн, хуулийн этгээдэд” гэж, 85 дугаар зүйлийн 85.5 дахь хэсгийн “нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн” гэснийг “хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн” гэж, 90 дүгээр зүйлийн 90.2 дахь хэсгийн “Уг гомдлыг энэ хуулийн 85 дугаар зүйлд заасан журмаар хэлэлцэж дараахь байдлаар шийдвэрлэнэ:” гэснийг “Энэ хуулийн 90.1-д заасны дагуу гаргасан гомдлыг 10 хоногийн дотор Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр дараахь байдлаар шийдвэрлэж тогтоол гаргана:” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “жинхэнэ” гэснийг, мөн зүйлийн 3.1.4 дэх заалтын “/тогтоол, дүрэм, заавар, журам/-” гэснийг, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “хууль бус” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.1.6 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.2.6 дахь заалтын “, эсхүл” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.1.6 дахь заалтын “захиргааны хэргийн” гэснийг, 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсгийн “гуравдагч этгээд” гэснийг, 88 дугаар зүйлийн 88.1.4 дэх заалтын “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой дутагдал илэрсэн, эсхүл шийдвэрт нөлөөлж болохуйц шинэ нотлох баримт илэрсэн бол захиргааны хэргийн” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-20.1.5 дахь заалт, мөн зүйлийн 20.2.3 дахь заалт, 34 дүгээр зүйлийн 34.1.9, 34.1.10 дахь заалт, 35 дугаар зүйл, 52 дугаар зүйлийн 52.5-52.8 дахь хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсэг, 67 дугаар зүйлийн 67.6 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсэг, 75, 76 дугаар зүйл, 85 дугаар зүйлийн 85.6 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 11 дүгээр
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

**ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Дархлаажуулалтын тухай хуулийн 17 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 17. 2 дахь хэсэг нэмсүгэй:

1/ 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг:

"17.2. Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товллын дагуу 0-15 насны хүүхдэд хийх дархлаажуулах бэлдмэлийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гэрчилгээтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрээс худалдаж авна."

2 дугаар зүйл. Дархлаажуулалтын тухай хуулийн дарваахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалт:

"6.2.4. Олон улсын эрүүл мэндийн дүрэм болон Монгол Улсын олон улсын гэрээний дагуу тодорхой нэрийн сэргийлэх тарилга хийгдэх ёстой улс оронд зорчих тохиолдолд шаардагдах тарилгыг хийлгэх."

2/ 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг:

"10.1. Заавал хийх дархлаажуулалтад сүрьеэ, халдварт саа /полиомиелит/, В вируст гепатит, сахуу, хөхүүл ханиад, татран, улаанбурхан, В хэв шинжийн хемофиллос инфлюэнза нянгийн халдвар, гахай хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилга орно."

3/ 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:

"10.4. Эрүүл мэндийн холбогдох байгууллага нь сүрьеэ, халдварт саа /полиомиелит/, В вируст гепатитын эсрэг дархлаажуулах бэлдмэлийг хүүхдийг төрсний дараа 24 цагийн дотор хийж, сэргийлэх тарилгын гэрчилгээ олгоно."



4/ 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг:

"16.1.Дархлаажуулах бэлдмэлийн чанар, хадгалалт, тээвэрлэлт болон аюулгүй байдлын талаар тавих улсын хяналтыг холбогдох эрх бүхий мэргэжлийн хяналтын байгууллага болон тухайн эрүүл мэндийн байгууллагын дотоод хяналтаар хэрэгжүүлнэ."

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д. ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 11 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар
хот

**Төрийн өндөр албан тушаалтан болон
түүнтэй адилтгах албан тушаалтны
албан тушаалын цалингийн хэмжээг
шинэчлэн тогтоох тухай тогтоолын
хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.9 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. "Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2010 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 50 дугаар тогтоолын хавсралтын 1 дэх заалтын "ТӨ-1"-д хамаарах хэсгийн "1424435" гэснийг "1095720" гэж өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолыг 2010 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д. ДЭМБЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**2010 оны 11 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 240

Улаанбаатар
хот**Элчин сайдыг эгүүлэн татах,
томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 3, "Дипломат албаны тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чойжилжавын Болдыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Кадырын Сайрааныг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Ц.ЭЛБЭГДОРЖ****МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2010 оны 9 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 250

Улаанбаатар
хот**Хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын 4.8.3, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.7-д заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийг улс орны бүтээн байгуулалтад оролцоход дэмжлэг үзүүлэх "Зөгийн үүр" хөтөлбөрийг 1 дүгээр, "Зөгийн үүр хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. "Зөгийн үүр хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийн төсөлд тусгах, тодорхой хэсгийг гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт,



Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо /Ч.Хашчулуун/-нд даалгасугай.

3.Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

**Засгийн газрын 2010 оны 250 дугаар
тогтоолын хавсралт**

"ЗОГИЙН ҮҮР" ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын 4.8.3-т "гадаадад ажиллаж, амьдарч байгаа, өндөр боловсрол, мэргэжил эзэмшсэн монгол иргэдийг эх орондоо буцаж ирж ажиллах сонирхлыг төрүүлэхүйц эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж, өөрийн мэргэшсэн чиглэлээрээ ажлын байр бий болгох санал, санаачилгыг хөхиүлэн дэмжих" стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр заасан.

Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.7-д гадаад оронд удаан хугацаагаар ажиллаж, сурч, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн эрх, нийгмийн асуудлаар хөтөлбөр, хууль боловсруулан гаргаж, хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улс бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрүүдийг эдийн засаг, нийгмийн салбарт хэрэгжүүлж эхэлж байгаатай холбогдон 2010-2015 онд өндөр технологийн аж үйлдвэрийн салбарт шаардагдах ажиллах хүчний эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд энэ хугацаанд хөдөлмөрийн зах зээл дээр нийт 40000 гаруй ажлын байр шинээр бий болохоос, 6000 гаруй нь инженер, техникийн ажлын байр байна.

Засгийн газраас хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн ажиллах хүчнийг бэлтгэж, нийлүүлэх ажлыг зохион байгуулахад



онцгой анхааран ажиллаж байгаа хэдий ч хөдөлмөрийн зах зээл дээр нарийн мэргэжил, өндөр ур чадвартай хүний нөөц хангалттай бус байна. Нөгөө талаас өнөөдрийн байдлаар албан бус тоогоор 116000-200000 Монгол Улсын иргэн хилийн чанадад сурч, ажиллаж, амьдарч байгаа нь манай улсын нийт ажиллах хүчний 9.3-18.6 хувийг эзэлж байна. Эдгээр иргэдийнхээ мэдлэг, ур чадвар, нөөц бололцоог улс орны бүтээн байгуулалтад татан оролцуулах нь хөдөлмөрийн зах зээл дээрх өндөр ур чадвар бүхий ажиллах хүчний эрэлт, хэрэгцээг хангах, төрийн алба, хувийн хэвшил, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудыг чадавхижуулах, шинэ мэдлэг, дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлэхэд чухал ач холбоцолтой гэж үзэж байна.

Хилийн чанадад өндөр боловсрол, мэдлэг, ур чадвар эзэмшин ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийг эх орондоо урт, богино хугацаагаар эргэн ирж ажиллах, бизнес эрхлэх, гадаадын дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, мэдлэг дамжуулах, хөрөнгө оруулалт татах зэрэг олон хэлбэр, чиглэлээр эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, үйл ажиллагаа

2.1. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь хилийн чанадад сурч, ажиллаж, амьдарч байгаа өндөр боловсрол, нарийн мэргэжил эзэмшсэн Монгол Улсын иргэдийг эх орондоо эргэн ирж ажиллах болон хилийн чанадаас мэдлэг, туршлага, боломжоо улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх асуудалд чиглүүлэн ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх, тэдгээрийн оновчтой санал, санаачилгыг дэмжих, хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулах замаар хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийг эх орныхоо хөгжил, бүтээн байгуулалтад татан оролцуулахад оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилт

2.2.1. Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараахь зорилтыг дэвшүүлж байна:

2.2.1.1. хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийг эх орондоо ирж ажиллах, амьдрахад шаардлагатай бодит мэдээллээр хангах, тэдний боловсрол, мэргэжлийн туршлага, ур чадварын талаар мэдээллийн сан үүсгэх, судалгаа хийх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг



гадаадад байгаа монгол иргэдийн талаар мэдээллээр хангах;

2.2.1.2. Монгол Улсын иргэд хилийн чанадаас эргэн ирж хөдөлмөр эрхлэх, бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэх болон хилийн чанадад байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэх, хамтран ажиллахад нь бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, зуучлах хэлбэрээр тэдэнд дэмжлэг үзүүлэх;

2.2.1.3. хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх салбар, чиглэлийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн зах зээл дээр онц шаардлагатай ажлын байранд ирж ажиллах тохиолдолд урамшуулал олгох.

2.3. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.3.1. Хөтөлбөрийн 2.2.1.1-д заасан зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.3.1.1. хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийн боловсрол, мэргэжлийн туршлага, ур чадварын талаар цогц судалгаа явуулж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэн тогтмол баяжуулж байх;

2.3.1.2. монголын аж ахуйн нэгж, байгууллага болон хилийн чанадад байгаа монгол Улсын иргэд мэдээллээр байнга холбогдож, мэдээлэл солилцоход нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр онлайн портал (вэб сайт, электрон мэдээллийн сан, санал солилцох форум) ажиллуулах;

2.3.1.3. хилийн чанадаас эргэн ирж хөдөлмөр эрхэлж байгаа болон хилийн чанадаас монголын аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллаж байгаа Монгол Улсын иргэдийн туршлагыг сурталчлах, түгээн дэлгэрүүлж урамшуулах, энэ чиглэлээр үзэсгэлэн, уулзалт, форум зохион байгуулах.

2.3.2. Хөтөлбөрийн 2.2.1.2-т заасан зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.3.2.1. Монгол Улсын иргэд хилийн чанадаас эргэн ирж хөдөлмөр эрхлэх, бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэх болон хилийн чанадад байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх санал боловсруулах;

2.3.2.2. хилийн чанадад байгаа болон эргэж ирсэн



Монгол Улсын иргэдийг ур чадварт нь тохирсон ажлын байранд зуучлах, үүнтэй холбогдуулан Хөдөлмөрийн төв бирж болон бусад байгууллагын үйл ажиллагааны уялдааг сайжруулах;

2.3.2.3. хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд монголын ажил олгогчидтой хамтран бизнес эрхлэхэд зуучлах;

2.3.2.4. Монгол Улсын иргэд хилийн чанадаас эргэн ирж шинээр бизнес эхлүүлэх тохиолдолд зах зээлийн орчин болон төрийн үйлчилгээ, зээл, бизнес инкубаторт хамрагдах боломжийн талаар тэдэнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

2.3.2.5. хилийн чанадад байгаа болон эргэж ирсэн Монгол Улсын иргэдийг хууль, эрх зүйн орчин, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээ (шинэ нөхцөлд дасан зохицоход нь шаардлагатай бусад)-тэй холбоотой мэдээллээр нэг цэгээс хангах.

2.3.3. Хөтөлбөрийн 2.2.1.3-т заасан зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.3.3.1. Монгол Улсын иргэд хилийн чанадаас эргэн ирж Монгол Улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

2.3.3.2. Монгол Улсын иргэд хилийн чанадаас эргэн ирж эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, салбарт хэрэгжиж байгаа, дотоодын хөдөлмөрийн зах зээлээс нөхөгдөх боломжгүй бөгөөд ажиллах хүчин онц шаардлагатай төсөл (ашгийн бус байгууллага)-д ирж ажиллах тохиолдолд урамшуулал олгох;

2.3.3.3. төрийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан Монгол Улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл (дотоодын хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт ихтэй болон инженер, технологийн нарийн мэргэжил)-ээр олон улсын нэр хүнд бүхий сургуульд амжилттай сурч байгаа оюутан, судлаачдад судалгааны тэтгэлэг олгох.

2.4. Хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх ерөнхий нөхцөл

2.4.1. Хөтөлбөрийн 2.2.1.3-т дэвшүүлсэн зорилтын хүрээнд санхүүгийн дэмжлэгт хамрагдахад дараахь нөхцөлийг хангасан байна:

2.4.1.1. Монгол Улсын иргэн байх;



2.4.1.2. Монгол Улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий сургуульд магистр болон түүнээс дээш зэрэгтэй төгссөн байх, эсхүл эдгээр чиглэлээр өндөр технологийн салбарт 2-оос доошгүй жил ажилласан байх;

2.4.1.3. хөтөлбөрийн 2.3.3.1-д заасан санхүүгийн дэмжлэгт хамрагдахад энэ хөтөлбөрийн 2.4.1.1, 2.4.1.2-т зааснаас гадна тухайн төсөл, хөтөлбөрийг Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах журамд нийцүүлэн боловсруулсан байх;

2.4.1.4. хөтөлбөрийн 2.3.3.2, 2.3.3.3-т заасан санхүүгийн дэмжлэгт хамрагдахад энэ хөтөлбөрийн 2.4.1.1, 2.4.1.2-т зааснаас гадна Монгол Улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх салбарт үйл ажиллагаа явуулж байгаа үндэсний аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллаж байгаа, эсхүл ажиллахаар гэрээ байгуулсан байх /тухайн ажлын байран дээр 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллах/.

Гурав. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах

3.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг өдөр тутам удирдан зохион байгуулах, явц, үр дүнд хяналт тавих ажлыг "Хилийн чанад дахь Монгол Улсын иргэдтэй хамтран ажиллах Зөвлөл" (цаашид "Зөвлөл" гэх) зохион байгуулах бөгөөд энэ хүрээнд дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангах;

3.1.2. хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг холбогдох Засгийн газрын тусгай сангаас санхүүжүүлэх саналыг тухайн сангийн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлэх;

3.1.3. их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага болон төрийн бус байгууллагыг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажиллагаанд татан оролцуулах, энэ чиглэлээр хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллах, арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

3.1.4. хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэнтэй гэрээ байгуулж ажиллах, тухайн иргэн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд санхүүгийн дэмжлэг, цалингийн нэмэгдэл, урамшуулал, судалгааны тэтгэлгийг нөхөн төлүүлэх;



3.1.5. хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад байнгын хяналт-цажиглгаа, үнэлгээ хийх.

3.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хүн амын бүртгэлийг төгөлдөржүүлэх зорилт, "Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр", "Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" болон Засгийн газраас хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлийн томоохон төслүүдтэй уялдуулан зохион байгуулна.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

4.1. Хөтөлбөрт заасан арга хэмжээг 2010-2012 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг дараахь хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ:

5.1.1. улсын төсөв;

5.1.2. хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хандив;

5.1.3. гадаадын зээл, тусламж.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийн төсөлд тусгаж, тодорхой хэсгийг гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлнэ.

Зургаа. Шалгуур үзүүлэлт, хүлээгдэж байгаа үр дүн

Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд:

Зорилтот үзүүлэлт	2010 он	2011он	2012 он
Хөтөлбөрийн санхүүжилт			
Хөтөлбөрийн нийт санхүүжилтийн хэмжээ	100 сая.төг	400 сая.төг	420 сая.төг
Мэдээллийн хангамжийн түвшингийн үзүүлэлт			
Нэгдсэн бүртгэлд хамрагдсан гадаадад байгаа иргэдийн тоо	15000	30000	45000



Хилийн чанадад зохион байгуулсан үзэсгэлэн, уулзалт, форум	1	8	8
Үзэсгэлэн, уулзалт, форумд хамрагдсан хүний тоо	500	1600	1600
Онлайн порталд хандагчдын тоо /өдрөөр/	3000	20000	30000
Санал болгосон ажлын байрны тоо	1000	2000	3000

Ажлын байр зуучлалын тоо, чанарын үзүүлэлт

Төрийн албанд	-	30	35
Эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуульд	10	45	55
Эрүүл мэндийн салбарт	5	50	60
Бусад салбарт	20	200	250

Шинээр эхэлсэн бизнестэй холбогдох үзүүлэлт

Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн тоо	-	25	35
Технологийн чиглэлийн хуулийн этгээдийн тоо	-	9	18
Шинээр бий болсон ажлын байрны тоо	-	20	30
Борлуулалтын хэмжээ	-	250 сая	650 сая

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн төслийн үзүүлэлт, тэдгээрийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийн үзүүлэлт

Тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр	2	20	40
Төсөл, хөтөлбөрийн нийт санхүүжилтийн хэмжээ	20 сая.төг	200 сая.төг	400 сая.төг
Хөтөлбөрт хамрагдах хүний тоо	15000	30000	45000

**"ЭБГИЙН ҮҮР" ХӨТӨЛӨВРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Харуцах байгууллага	Хугацаа	Шардалагатай санхүүжилтийн хэмжээ (төгрөг)
	Нэг. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийг эх орондоо ирж ажиллах, амьдрахад шардалагатай бодит мэдээллээр хангах, тэдний боловсрол, мэргэжлийн туршилага, ур чадварын талаар мэдээллийн сан үүсгэх, судалгаа хийх, аж ахуйн нэгж байгууллагуудыг гадаадад байгаа монгол иргэдийн талаар мэдээллээр хангах.			
1.1	Төрийн болон төрийн бус байгууллагын мэдээллийн сангуудыг нэгтгэж, нэгдсэн сүлжээнд хамруулан байнга байжуулах, гадаадад суугаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар болон холбогдох бусад байгууллагыг мэдээллээр хангах.	Зөвлөл, ГХЯ, БСШУЯ, УБЕГ, ТББ	2010-2012	20 сая
1.2	Төрөлхсөн мэдээллийн сангуудыг үүсгэн байжуулж байх (мэргэжил, ажиллах байгаа салбар, судалгааны чиглэл, эрдэм шинжилгээний бүтээлийн төрөлжүүлсэн мэдээллийн санг бий болгох)	Зөвлөл, ГХЯ, Дипломат төлөөлөгчийн газар, БСШУЯ, ТББ	2010-2012	10 сая
1.3	Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийн ур чадвар, мэргэжлийн дэдлэглэл, туршилагын талаар асуулга, судалгаа хийж Хоёр Монголын аж ахуйн нэгж, байгууллага болон хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд мэдээллээр байнга холбогдож, мэдээлэл солилцоход нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр онлайн портал (вэб сайт, электрон мэдээллийн сан, санал солилцох форум) ажиллуулах	Зөвлөл, Хөдөлмөрийн төв Бирж	2010	10 сая
2.1	Иргэд ажил олгогчид, төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллээр хангахад чиглэсэн мэдээлэл солилцооны онлайн портал бий болгох	Зөвлөл, УБЕГ	2010-2012	5 сая
2.2	Онлайн порталгаар дамжуулан хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийг буртгаж, тогтмол байжуулах	Зөвлөл, УБЕГ	2010-2012	5 сая
2.3	Онлайн порталгаар дамжуулан ажил олгогчид ажилны байрны холбогдолтой мэдээлэл, ажил хайгчид өөрийн боловсрол, ур чадварын талаархи мэдээлэл солилцох, гадаад, дотоод аугсгорынгийн хүний нөөцийн мэдээллийн бааз бүрдүүлэх	Зөвлөл, НЭДТГ, Хөдөлмөрийн төв Бирж	2010-2012	5 сая
	Гурав. Хилийн чанадаас эргэн ирж бизнесийн үйл ажиллагаа, хөдөлмөр эрхэлж байгаа болон хилийн чанадаас монголын аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллаж байгаа Монгол Улсын иргэдийн туршилагыг сурталчлах, тугаан дэлгэрэнгүйг урамшуулах, энэ чиглэлээр үзэсгэлэн, уулзалт, форум зохион байгуулах			



3.1	Хилийн чанадаас эргэн ирж хөдөлмөр эрхэлж байгаа болон хилийн чанадаас монголын аж ахуйн нэгж, байгууллагад хамтран ажиллаж байгаа иргэдийн туршилагыг Монгол Улсад болон хилийн чанадад сурталчлах, тусламь дэмжлүүлж үрэмшүүлэх, энэ чиглэлээр үзэжлэл, уулзалт, форум зохион байгуулах	Зөвлөл, Холбогдох яамд, ТББ	2011-2012	17 сая
Дөрөв, Монгол Улсын иргэд хилийн чанадаас эргэн ирж хөдөлмөр эрхлэх, бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэх болон хилийн чанадад байгаа иргэд монголын аж ахуйн нэгж, байгууллагад хамтран ажиллах эрх зүйн тавтай оршиж буцаулах санал боловсруулах				
4.1	"Зөгийн үр" хөтөлбөрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхийг хамтран зохион байгуулах Зөгийн үрэн тусгай сангуудын хөрөнгийг захиран зарцуулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах	Зөвлөл, СЯ	2010	-
4.2	Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд эх орондоо эргэж ирэхэд эрүүл мэндийн дээтэлд шүүд хамруулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудлыг судлах, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах	Зөвлөл, ЗМЯ, НОХЯ, ГХЯ	2010-2012	2 сая
4.3	Гадаадад байгаа иргэд монголын ажил олгогчидтой хамтран бизнес эрхлэх тохиолдолд тэдгээрийг Монгол Улсад нийгмийн даатгалын системд хамруулах асуудлыг судлах, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах	Зөвлөл, НОХЯ, ГХЯ	2010-2012	2 сая
4.4	Төрийн албанд ажиллаж байгаад төрийн сангийн зээлээр гадаадад магистр, докторантурт суралцаж ирсэн иргэдийг өмнө нь ажиллаж байсан газарт нь буцааж авах, гадаадад олон улсад нэр хүнд бүхий сургууль төгссөнд төрийн албанд шинээр орж ажиллах боломжийг нэхэ чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах	Зөвлөл, ХЗДХЯ, БСШУЯ, ТАЗ	2010-2012	2 сая
Тав, Хилийн чанадад байгаа болон эргэж ирсэн Монгол Улсын иргэдийг үр чадварт нь тохирсон ажлын байранд зүүлэх, үүнтэй холбогдуулан Хөдөлмөрийн төв бирж болон бусад байгуулалтын үйл ажиллагааны үндэсэл сайжруулах				
5.1	Хилийн чанадаас эргэн ирж байгаа иргэдийг үр чадварт нь тохирсон байглын ажлын байранд зүүлэх	Зөвлөл, ТАЗ, ТӨХ, Хөдөлмөрийн төв бирж, ТББ	2010-2012	6 сая
5.2	Хилийн чанадаас эргэн ирж байгаа иргэдийг богино хугацаагаар ирж ажиллахад зүүлэх	Зөвлөл, холбогдох яамд, Хөдөлмөрийн төв бирж, ТББ	2010-2012	5 сая
Зургаа, Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд монголын ажил олгогчидтой хамтран ажил олгогчидтой хамтран бизнес эрхлэхэд байгаа болон хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд				
6.1	Монгол Улсын иргэд монголын ажил олгогчидтой хамтран бизнес эрхлэхэд болон хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд	Зөвлөл, Холбогдох яамд, ТББ	2010-2012	6 сая



	Монголд байгаа байгууллагуудын захиалгаар судалгааны ажил хийхэд зүүсэх		
	Дотоо Монгол Улсын иргэд хилийн чанадаас эргэн ирж шинээр бизнес эхлүүлэх тохиолдолд зах зээлийн орчин болон төрийн үйлчилгээ, зээл, бизнес инкубатор хамрагдах боломжийн талаар тэдэнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх		
7.1	Бизнесийн үйл ажиллагаа явуулахыг дэмжих (Бизнес эрхлэх талаар сургалтад хамруулах, бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, инкубатор, аж үйлдвэрийн паркэд үйл ажиллагаа явуулах давуу эрх олгох)	Зөвлөл, НЭДТГ, ТББ	2010-2012 6 сая
	Найм, хилийн чанадад байгаа болон эргэн ирсэн Монгол Улсын иргэдийг хууль, эрх зүйн орчин, ариун манд, боловсрол, нийгмийн үйлчилгээ (шанг нөхцөлд дасан зохицоход нь шаардлагатай бусад)-тай холбоотой мэдээллээр нэг цэгээс хангах		
8.1	Эх орондоо дасан зохицоход нь туслэх зорилгоор хууль, эрх зүйн орчин, ариун манд, боловсрол, нийгмийн үйлчилгээ (шанг нөхцөлд дасан зохицоход нь шаардлагатай бусад)-тай холбоотой мэдээллээр нэг цэгээс хангах	Зөвлөл, ТББ	2010-2012 15 сая
	Ес, Монгол Улсын иргэд хилийн чанадаас эргэн ирж Монгол Улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн хуранд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх		
9.1	Бизнесийн төсөлд дараахь хэлбэрээр санхүүгийн дэмжлэг үзүүлнэ: -контракттай зээл олгох (20 сая хуртал төгрөг) -бизнесийн зөвлөх үйлчилгээг бүрэн болон хэсэгчлэн санхүүжүүлэх (5 сая хуртал төгрөг)	Зөвлөл, ХХААХҮЯ, НОХЯ	2011-2012 250 сая
9.2	Судалгааны (зах зээлийн, технологийн) төсөлд дараахь санхүүгийн дэмжлэг үзүүлнэ: -замын зардал (2 сая хуртал төгрөг) -судалгааны зардал (10 сая хуртал төгрөг)	Зөвлөл, БСШУЯ	2011-2012 200 сая
9.3	Хүмүүнлэгийн төсөлд дараахь санхүүгийн дэмжлэг үзүүлнэ: -замын зардал (2 сая хуртал төгрөг) -урамжуулал (хэрэгжүүлж буй хүмүүнлэгийн төслийн үеийн дүнгийн 10 хуртал хувьтай тэнцэх хэмжээтэй)	Зөвлөл, ЗМЯ	2011-2012 10 сая
9.4	Болоно хугацаагаар ирж байхал, зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд дараахь санхүүгийн дэмжлэг үзүүлнэ: -замын зардал (2 сая хуртал төгрөг) -урамжуулал (2 сая хуртал төгрөг)	Зөвлөл, БСШУЯ, ХХААХҮЯ, ЗМЯ	2011-2012 45 сая

<p>9.5</p>	<p>Дэвшилтэт техник, технологийн нэвтрүүлэхэд дараахь санхүүгийн дэмжлэг үзүүлэнэ: -замын зардал (2 сая хүртэл төгрөг) -нэвтрүүлж буй технологийг эдийн засаг, нийгмийн үр ашгаас хамгааран урамшуулал (1-10 сая хүртэл төгрөг)</p>	<p>Зөвлөл, БСШУЯ, ХХААХУЯ, ЭМЯ, НӨДТГ</p>	<p>2011-2012</p>	<p>100 сая</p>
<p>9.6</p>	<p>Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дараахь санхүүгийн дэмжлэг үзүүлнэ: -замын зардал (2 сая хүртэл төгрөг) -урамшуулал (1 сая хүртэл төгрөг)</p>	<p>Зөвлөл, ГХЯ</p>	<p>2011-2012</p>	<p>15 сая</p>
<p>10.1</p>	<p>Арав, Монгол Улсын иргэд хилийн чанадаас эргэн ирж эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, салбарт хэрэглэж байгаа, дотоодын худалдааны зах зээлээс нөвөгдөх босомжгүй бөгөөд ажиллах хүчин өнц шаардлагатай төсөл (жилийн бус байгууллага)-д ирж ажиллах тохиолдолд урамшуулал олгох</p>	<p>Зөвлөл, холбогдох яам, агентлагууд</p>	<p>2011-2012</p>	<p>152 сая</p>
<p>11.1</p>	<p>-Замын зардалын дэмжлэг 2 сая хүртэл төгрөг байна -Тээврийн зардалын дэмжлэг 2 сая хүртэл төгрөг байна -Дээд тал нь 6 сарын хугацаатай сарын 500 мянган төгрөг хүртэл урамшуулал олгоно -Төрийн албанд ажиллах тохиолдолд ажилласан хугацаа харгалзахгүйгээр төрийн албан хаагчийн орон сууцны эзэлд хамруулах, орон сууцны урьдчилгаа төлбөрийн 5 сая хүртэл төгрөгийг санхүүжүүлнэ</p>	<p>Зөвлөл, БСШУЯ, холбогдох бусад яамд</p>	<p>2011-2012</p>	<p>30 сая</p>
<p>Нийт</p>	<p>Нийт</p>	<p></p>	<p></p>	<p>920 сая</p>



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2010 оны 11 дүгээр
сарын 17-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 12.45 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Наранчимэг даргалж, гишүүн П.Очирбат, Ж.Амарсанаа /илтгэгч/, Д.Мөнхгэрэл, Б.Пүрэвням нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Г.Агар-Эрдэнийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд гомдол гаргагч иргэн Н.Ариунболд, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Загджав нар оролцов.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Ариунболд Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

"... Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 50.7-д сонгуулийн санал хураалтын дүнгийн талаархи маргааныг сонгуулийн дунд шатны байгууллага болох тойргийн хороо эцэслэн шийдвэрлэж байхаар заажээ. Өөрөөр хэлбэл санал хураалтын дүн сонгуулийн хэсгийн болон тойргийн хэмжээнд маргаантай байгаад саналын хуудас дахин тоолуулахтай холбогдон гарсан маргааныг тойргийн хороо эцэслэн шийдвэрлэж байх хэм хэмжээ Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд "тогтоогджээ".

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 19.10-т зааснаар хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд л тойргийн хорооны шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо хянан шийдвэрлэдэг ба санал хураалтын дүнгийн талаархи буюу санал дахин тоолохтой холбогдсон маргааныг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.7-д өөрөөр заасан тул энэ төрлийн маргааныг сонгуулийн төв байгууллага авч хэлэлцэхгүй. Түүнчлэн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57.5-д сонгуулийн төв байгууллагын хянан шийдвэрлэх маргааныг тусгайлан заасан бөгөөд



уг хэсэгт санал дахин тоолохтой холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрх Сонгуулийн ерөнхий хороонд олгогдоогүй байна. ...

... Нэгэнт сонгуулийн санал хураалтын дүн буюу саналын хуудсыг дахин тоолох тухай маргааныг Сонгуулийн төв байгууллага хянан шийдвэрлэх эрх зүйн үндэслэлгүй тул тухайн асуудлаар үүссэн маргаан нь Үндсэн хуулийн цэцийн харьяаллын бус. Өөрөөр хэлбэл санал тоолох ажиллагаа нь хууль бус байснаас санал хураалтын дүнгийн талаар маргаан гарч дахин санал тоолох тухай маргаан гарвал уг асуудлыг шийдвэрлэх эрх мэдэл Үндсэн хуулийн цэцэд алга байна. ...

... Харин Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.7-д сонгуулийн санал хураалтын дүнгийн талаархи маргаан буюу санал дахин тоогуулахтай холбогдсон хэрэг маргааныг шүүхээс өмнө маргаан урьдчилан шийдвэрлэх энэхүү шатанд эцэслэн шийдвэрлэгдэхээр заасан нь Монгол Улсын иргэний зүгээс улс төрийн эрх, эрх чөлөөгөө зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлаж, улмаар шүүхийн "шүүх" эрх мэдлийг хязгаарласан байна. ...

... Гэвч Улсын Их Хурлын сонгуулийн санал хураалтын дүнгийн талаархи маргаан буюу санал дахин тоолохтой холбогдсон хэрэг маргаан шүүхээс өмнө маргаан урьдчилан шийдвэрлэх шатанд эцэслэн шийдвэрлэгдэхээр Улсын Их Хурлын сонгуулийн тухай 50.7-д туссан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дахь заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах ... эрхтэй", Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум, сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ..." гэсэнтэй нийцэхгүй байна." гэжээ.

Хоёр. Дээрх мэдээллийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Болдбаатар урьдчилан шалгаж 2010 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 54 дугаар тогтоолоор маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан бөгөөд уг тогтоолын үндэслэлд:

"Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт санал хураалтын дүнгийн талаар гарсан маргааныг тойргийн хороо эцэслэн шийдвэрлэнэ хэмээн заасан нь мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсэгт заасан ерөнхий журмаас өөр байх бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 156 дугаар зүйлийн 156.1.1 дэх заалтад "... Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1, 4.2-т зааснаас бусад байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан



тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд ...” хэмээн заасны дагуу тойргийн хорооны шийдвэрийг шүүх гомдлоор авч хэлэлцэхээр байна.”

Үндсэн хуулийн цэц нь 2006 оны 5 дугаар дүгнэлтээрээ Сонгуулийн ерөнхий хороо сонгуультай холбоотой маргааныг эцэслэн шийдвэрлэхээр заасан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтууд Үндсэн хуульд заасан иргэний шүүхэд хандах эрхийг зөрчөөгүй байна хэмээн шийдвэрлэж байсан байна... ” гэжээ.

Гурав. Иргэн Н.Ариунболд Цэцийн гишүүний дээрх тогтоолыг эс зөвшөөрч Үндсэн хуулийн цэцэд дахин хандаж гомдол гаргасан бөгөөд уг гомдолд:

“... Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.7-д “...эцэслэн...” гэсэн нь буюу санал хураалтын дүнгийн талаар үүссэн маргааныг тойргийн хороо эцэслэн шийдвэрлэж байхаар заасан нь Үндсэн хууль зөрсөн тухай мэдээллийг хянан шалгаж маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан шийдвэр гаргахдаа мэдээлэлд хавсаргасан нотлох баримтыг дутуу эсхүл үнэлээгүй байна. ...

... Өөрөөр хэлбэл Монгол Улсын шүүх, сонгуулийн тойргийн хороонд холбогдуулан санал хураалтын дүнгийн талаар гаргасан гомдлыг хэргийн харьяалал зөрсөн буюу тухайн маргаан нь шүүхийн бус Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан гэж үзэн шийдвэрлэж, улмаар уг шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болжээ.

Иймд Монгол Улсын шүүхийн шүүгчийн “хэрэг хүлээн авахаас татгалзсан” шийдвэрийн үндэслэл, Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2010 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 54 дүгээр тогтоолын үндэслэлээс илт зөрүүтэй байгаа тул нотлох баримтыг судлан, Цэцийн гишүүний 2010 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 54 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцон мэдээллийг хянан шалгаж өгнө үү.” гэжээ.

Дөрөв. Дээрх гомдлыг Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдаанаар хянан хэлэлцээд 2010 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр 20 дугаар магадлал гаргасан байна. Уг магадлалын үндэслэх хэсэгт:

“Үндсэн хуулийн цэц 2006 оны 05 дугаар дүгнэлтээрээ Сонгуулийн ерөнхий хороо сонгуультай холбоотой маргааныг эцэслэн шийдвэрлэхээр заасан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалт Үндсэн хуульд заасан иргэний шүүхэд хандах эрхийг зөрчөөгүй байна гэж шийдвэрлэсэн байна. Харин 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдөр



Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийн заалтаар санал хураалтын дүнгийн талаар маргаан гарвал тойргийн хороо эцэслэн шийдвэрлэж байхаар нэмэлт оруулжээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт " ... эцэслэн ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн эсэх талаар иргэн Н.Ариунболдын гаргасан гомдол үндэслэлтэй байна." гэжээ.

Тав. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Загджаваас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбарт:

"... Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.7-д заасан "санал хураалтын дүн" гаргах ажиллагаа нь саналын хуудас тоолох ажиллагаа бөгөөд уг ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тусгайлан эрх олгосон сонгуулийн байгууллага болох хэсгийн хороонд олгосон бөгөөд өөр ямар ч байгууллагад энэхүү эрхийг олгоогүй байна.

Харин тойргийн хороо хэсгийн хороодоос ирүүлсэн санал хураалтын дүнг хуульд заасан үзүүлэлтээр нэгтгэж, тухайн тойргийн санал хураалтын эцсийн дүнг гаргадаг. /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.1 дэх хэсэг/

Сонгуулийн санал хураалтын дүнгийн талаарх маргаан шат шатны шүүх, сонгуулийн хороодоор дамжин сунжрах, хугацаа алдах, сонгуулийн дүн гарахгүй удаахрах, үүний улмаас сонгуулийн үр дүн хуульд заасан хугацаанд гарахгүй байх, төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох, цаашлаад төрийн гүйцэтгэх дээд байгууллагыг эмхлэн байгуулах хугацаа хойшлох, хууль ёсоор саналаа өгсөн мянга мянган сонгогчдын төлөөлөл Улсын Их Хуралд сонгогдохгүй байх, сонгогчдын эрх ашиг хохирох зэрэг сөрөг үр дагаврыг арилгах үүднээс санал хураалтын дүнгийн талаар аливаа маргаан гарвал тухайн тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэж байхаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан.

Санал хураалтын дүнгийн талаар гарсан маргааныг тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэж байгаа нь тогтоосон тодорхой хугацаанд явагддаг сонгуулийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой. ...

... Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийн "эцэслэн" гэсэн нь Монгол Улсын Үндсэн



хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.” гэжээ.

Зургаа. 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр иргэн Н.Ариунболдоос Үндсэн хуулийн цэцэд мэдээллийн нэмэгдүүлсэн шаардлага ирүүлснийг Цэцийн гишүүн бие даасан мэдээлэл хэмээн үзсэн бөгөөд уг мэдээлэлд:

“... Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт “... эцэслэн ...” гэж заасан байгаа нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэхийг хянуулахаар гаргасан мэдээллийн шаардлагыг 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэг бүхэлдээ Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалт зөрчсөн эсэхийг хянуулахаар, шаардлагын зүйлээ хянаж байгаа асуудлын хүрээнд нэмэгдүүлж байна.

Нөгөө талаас тойргийн хороо гэх байгууллага нь сонгуулийг зохион явуулах зорилгоор төрөөс байгуулагддаг түр ажиллагаатай байгууллага. Цэцийн гишүүний 2010 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 54 дүгээр тогтоолд дурдсанчлан тойргийн хорооны шийдвэрт гомдогч шүүхэд гомдол мэдүүлэх боломжтой байлаа ч тойргийн хороо нь түр ажиллагаатай тул түүнтэй шүүхээр маргалдаж байх үед татан буугдвал, түүнчлэн татан буугдсаных нь дараа эрх нь зөрчигдсөн тухай мэдсэн этгээд нь тойргийн хороонд хамаарах асуудлаар шүүхэд мэдүүлэх, гомдлоо шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй болдог байна. ...” гэжээ.

Долоо. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Загджаваас 2010 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн нэмэлт тайлбарт:

“... Тойргийн хороо саналын хуудас тоолдоггүй бөгөөд зөвхөн тухайн тойргийн хороонд харъяалах салбар болон хэсгийн хорооны санал хураасан дүнгийн тухай шийдвэрийг үндэслэн тойргийн хэмжээнд сонгуулийн дүнг нэгтгэх үйл ажиллагаа явуулдаг сонгуулийн байгууллага юм. /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 16.2.10 дахь заалт/.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.1 дэх хэсэгт “Тойргийн хороо нь салбар болон хэсгийн хороодоос ирүүлсэн санал хураалтын дүнг хуульд заасан үзүүлэлтээр нэгтгэж, тухайн тойргийн санал хураалтын эцсийн дүнг гаргана.” гэж заасан. Тойргийн хороо тухайн тойргийн санал хураалтын эцсийн дүнг гаргаж байж тухайн тойрогт хамгийн олон, гэхдээ сонгогчдын 25, түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцож, түр үнэмлэх олгоно. /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.3, 50.5 дахь хэсэг/. Энэ нь тойргийн хорооны бүрэн эрх бөгөөд сонгогдох эрхийн баталгаа болж байдаг онцлогтой.



Сонгуулийн санал хураалтын дүнгийн талаархи маргаан шат шатны шүүх, сонгуулийн хороодоор дамжин сунжрах, хугацаа алдах, сонгуулийн дүн гарахгүй удаашрах, үүний улмаас сонгуулийн үр дүн хуульд заасан хугацаанд гарахгүй байх, төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох, төрийн залгамж чанар алдагдах, цаашлаад төрийн гүйцэтгэх дээд байгууллагыг эмхлэн байгуулах хугацаа хойшлох, хууль ёсоор саналаа өгсөн мянга мянган сонгогчдын төлөөлөл Улсын Их Хуралд сонгогдохгүй байх, сонгогчдын эрх ашиг хохирох зэрэг сөрөг үр дагаврыг арилгах үүднээс санал хураалтын дүнгийн талаар аливаа маргаан гарвал тухайн тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэж байхаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан.

Өргөдөл гаргасан иргэн Н.Ариунболдын мэдээлэлд "тойргийн хороо гэх байгууллага нь сонгуулийг зохион явуулах зорилгоор төрөөс байгуулагддаг түр ажиллагаатай байгууллага, ...тойргийн хороо нь түр ажиллагаатай тул түүнтэй шүүхээр маргалдаж байх үед татан буугдвал... тойргийн хороонд хамаарах асуудлаар шүүхэд мэдүүлэх, гомдлоо шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй болдог байна" гэжээ. Санал хураалтын дүнгийн талаар аливаа маргаан гарвал тухайн тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэж байгаа нь тогтоосон тодорхой хугацаанд явагддаг сонгуулийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой бөгөөд санал хураалтын дүн, түүнтэй холбоотой аливаа гомдол, маргааныг тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ гэж хугацаа зааж өгч байгаа нь харин ч түр ажиллагаатай байгууллага тул тодорхой хугацааны дотор гарсан гомдол маргааныг шийдвэрлэж байх үүрэг ногдуулсан байх тул Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Энд "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 05 дугаар дүгнэлтийн Үндэслэл хэсэгт "Аливаа парламентын сонгууль улс даяар нэгэн зэрэг эхэлж товлосон цагт дуусгавар болдог нийтлэг зүй тогтолтой. Энэ нь сонгуулийг улс даяар нэгэн зэрэг саадгүй явуулах үндэс болдог хэмээн үздэг. Иймд сонгуулийн холбогдолтой аливаа маргааныг сонгууль явуулж дуустал шүүх болон хөндлөнгийн ямар нэгэн өөр байгууллага авч хэлэлцдэггүй журамтай байна." гэж тэмдэглэснийг онцлох нь зүйтэй гэж үзэж байна." гэжээ.

Найм. Иргэн Н.Аринболдоос Үндсэн хуулийн цэцэд хандаж 2010 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр нэмэлт тайлбар ирүүлсэн байна. Уг нэмэлт тайлбарт:



"... Монгол Улсад Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан хууль ёсны шударга шүүх хараат бусаар ажиллаж байгаа цагт шударга бус сонгуулийн тухай ярих нь илүүц юм. Гэвч Монгол Улсад шүүх эрх мэдлийн бүхэл бүтэн тогтолцоо ажиллаж байгаа боловч сонгуулийн холбогдолтой маргаан нь шударга шүүхийн хяналтын гадна үлджээ. Үүний нотолгоо нь 2008 оны Улсын Их Хурлын сонгуулийн дараа түүнтэй холбоотойгоор олон тооны маргаан үүсч байсан боловч сонгуулийн холбогдолтой нэг ч маргааныг шийдэж чадсангүй эрх мэдэл нь дутлаа.

"Шударга бус" сонгуулийн талаар гарсан гомдол, санал шударга шүүхийн хяналтын гадна үлдэж байгаа нь хууль, олон улсын гэрээгээр олгогдсон эрх, эрх чөлөөгөө зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулах, сэргээн тогтоолгохоор шүүхэд мэдүүлэх хамгаалуулах иргэний үндсэн эрхийг давхар зөрчсөн үр дагавар болж шүүхийн практикт тогтох хандлагатай боллоо. ...

... Гэтэл санал хураалтын үр дүн, санал тооллогын дүн худлаа, хууль бус тухай мэдээлэл авсан нэр дэвшигч нь түүнчлэн сонгогч нь нотлох баримтыг (саналын хуудас болоод түүнд холбогдох баримт) шалгуулан, улмаар "сонгох, сонгогдох" эрхээ хамгаалуулахаар "дахин санал тоолуулах" тухай гомдлыг шүүхэд мэдүүлэх боломжгүй болж, гаргасан ч шүүх нь хүлээж авахгүй байх хэм хэмжээг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 50.7-д тогтоожээ. Шүүгч нь нэгэнт хуульд захирагдах ёстойгоос хойш "хуулиа" барих нь мэдээж.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай мэдээллийг шалгаж, Үндсэн хуулийн хүрээнд асуудлыг шийдвэрлэж өгөхийг гүнээ хүсье." гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт санал хураалтын дүнгийн талаар гарсан маргааныг шийдвэрлэх эрхийг тойргийн хороонд хамааруулан хуульчилсан нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт санал хураалтын дүнгийн талаар гарсан маргааныг тойргийн хороо "эцэслэн" шийдвэрлэж байхаар заасан нь тухайн асуудлаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх сонгогч, сонгогдогчийн эрхийг зөрчихөд хүргэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь



хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт "...эцэслэн..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх ..." гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт "...эцэслэн..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ...", Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийн "... эцэслэн..." гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг хүлээн авч, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮД

Д.НАРАНЧИМЭГ

**П.ОЧИРБАТ
Ж.АМАРСАНАА
Д.МӨНХГЭРЭЛ
Б.ПҮРЭВНЯМ**

Хавт:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци.


Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin_medecelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 3

Индекс: 14003



Улсын Их Хурлын Төлмөн гэдэрийн хэвлэх хэсэгт хэвлэж,
Утас 329487